



044

БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 23 өдөр

Дугаар А/528

Булган

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6/а/, Хууль тогтоомжийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 16 сум, 1 тосгоны иргэд, төрийн алба хаагч нарт “Иргэдэд ойр эрх зүйн үйлчилгээ” сэдэвт хууль сурталчлах, эрх зүйн зөвлөгөө өгөх арга хэмжээг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулсугай.
2. Хууль сурталчлах, эрх зүйн сургалт сурталчилгааны зардалд 1204520 / нэг сая хоёр зуун дөрвөн мянга таван зуун хорь / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ